

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/79/НА-СТА-ТХН

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот

2024 он

Санхүү-нийцлийн газрын захирал,

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас: 261663 Цахим хаяг: Naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: Ч.Болд

Утас: 260512 Цахим хаяг: Boldch@audit.gov.mn

Аудитор: А.Баясгалан

Утас: 261628 Цахим хаяг: Bayasgalana@audit.gov.mn

Нийслэл-Аудит ХХК-ийн захирал: Т.Сугарсүрэн

Утас: 976-99115395 Цахим хаяг: info@niislelaudit.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.29 № 07/52/

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн үйл ажиллагаа нь Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Монгол мал” болон “Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөр-3” үндэсний хөтөлбөрүүдийн хүрээнд аймаг, сумдын малчин өрх, иргэдийн амьжиргааг дээшлүүлэх, орлогыг нэмэгдүүлэхэд чиглэгдэж байна.

Дэлхий нийтийг хамарсан цар тахалтай холбоотойгоор Монгол Улсын Засгийн газраас төслийг хэрэгжүүлэх хугацааг сунгах хүсэлт гаргасны дагуу Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангаас 2023 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийг хүртэл 2 жилийн хугацаагаар сунгаж, санхүүжилтийн хэлэлцээрийн дагуу төсөл нь 2024 оны 3 дугаар сарын 31-ний өдөр хаагдахаар байна.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Засгийн газар болон Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан хооронд байгуулсан 2011 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн хэлэлцээрийн хүрээнд олгосон “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл”-ийн зээллэгийн хөрөнгийн үлдэгдэл болох 756,844.84 ам доллартай тэнцэх хэмжээний төгрөгийг Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон

улсын сангаас өгсөн зөвлөмжийн дагуу “Хөдөө аж ахуйн загвар хоршоо, жижиг дунд үйлдвэрийг дэмжих” зорилгоор 2023 оны 10 дугаар сарын 12-ны өдрийн 104/03-706/49 тоот зээлийн гэрээний дагуу жижиг дунд үйлдвэрийн газарт дамжуулан зээлдүүлсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Тайлант онд төслийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтэд тусгагдсан 2 хөтөлбөр, 11 арга хэмжээний хэрэгжилт 100.0 хувь, хөтөлбөр, арга хэмжээнд зориулан зарцуулахаар төлөвлөж зарцуулсан төсвийн гүйцэтгэл 99.00 хувийн биелэлттэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,615,167,664.14	10,995,344,757.39
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	12,030,858,235.91	7,919,620,650.18
3121	Төгрөг	7,063,801,536.65	7,293,884,923.75
31211	Төрийн сангийн харилцах	1,487,088,493.04	1,721,084,923.75
312113	Төрийн сан 100900011865	25,136,746.31	15,758,243.31
312114	Төрийн сан 100900011934	1,223,956.22	483,163.89
312115	Төрийн сан 100900011943	824,809,836.63	1,068,925,562.67
312116	Төрийн сан 100900011944	635,917,953.88	635,917,953.88
31213	Арилжааны банк дахь харилцах	5,576,713,043.61	5,572,800,000.00
312133	Гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжих /Хас банк/	3,913,043.61	-
312134	Засгийн газрын ГСТ гадаад/зз ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн төслийн батлан даалтын хадгаламж Хадгаламж	5,572,800,000.00	5,572,800,000.00
31220	Гадаад валют	4,967,056,699.24	625,735,726.44
31223	Арилжааны банк дахь харилцах	4,967,056,699.24	625,735,726.44
312230	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл	2,394,976,437.56	43,385,886.79
312231	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл-Нэмэлт санхүүжилт	2,572,080,261.68	582,349,839.65
33	АВЛАГА	584,309,428.23	3,075,724,107.21
33500	Бусад авлага	584,309,428.23	3,075,724,107.21
3351	Байгууллагаас авах авлага	17,309,428.23	52,567,671.23
3360	Зээлийн авлага	567,000,000.00	3,023,156,435.98
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	207,935,226.81	47,797,382.44
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	207,935,226.81	47,797,382.44
39200	Биет хөрөнгө	204,796,337.99	47,797,382.44
39203	Авто-тээврийн хэрэгсэл	422,900,000.00	244,500,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(249,090,833.50)	(220,020,833.38)
39205	Машин, тоног төхөөрөмж (компьютер)	69,540,105.00	15,488,445.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(65,814,290.46)	(14,418,013.38)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,539,264.00	47,411,334.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(25,277,907.05)	(25,163,549.80)
39300	Биет бус хөрөнгө	3,138,888.82	0.00
39301	Программ хангамж	10,000,000.00	10,000,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(6,861,111.18)	(10,000,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,823,102,890.95	11,043,142,139.83
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,386,989,167.26	3,377,450,255.68
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,386,989,167.26	3,377,450,255.68
413	Өглөг	3,386,989,167.26	3,377,450,255.68
4120	Богино хугацаат зээлийн өглөг	3,913,043.63	-
4121	Төгрөг	3,913,043.63	-
41211	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	3,913,043.63	-
4130	Өглөг	8,364,867.95	2,739,000.00
41310	Ажиллагсадтай холбогдсон өглөг	3,683,566.30	-
41313	ХХОАТ өглөг	3,683,566.30	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,366,873.00	-
41360	Бусад өглөг	3,314,428.65	2,739,000.00
41361	Байгууллагад өгөх өглөг	2,739,000.00	2,739,000.00
41362	Хувь хүмүүст өгөх өглөг	575,428.65	-
41400	Урьдчилж орсон орлого	3,374,711,255.68	3,374,711,255.68

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	3,374,711,255.68	3,374,711,255.68
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	9,436,113,723.69	7,665,691,884.15
51	Засгийн газрын хувь оролцоо	9,436,113,723.69	7,665,691,884.15
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	9,436,113,723.69	7,665,691,884.15
51200	Хуримтлагдсан үр дүн	9,436,113,723.69	7,665,691,884.15
51210	Өмнөх үеийн үр дүн	8,013,611,975.50	9,437,480,596.69
51220	Тайлант үеийн үр дүн	1,422,501,748.19	(1,771,788,712.54)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	12,823,102,890.95	11,043,142,139.83

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл /төгрөгөөр/
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,752,833,315.00	610,454,461.36
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,497,349,915.00	399,254,041.36
120	Нийтлэг татварын бус орлого	5,497,349,915.00	399,254,041.36
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,448,525,085.00	385,666,041.36
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	588,753,762.04	385,666,041.36
120004202	НӨАТ-ын орлого	314,269,652.96	88,150,805.39
120004205	Батдан даалтын хөрөнгийн хадгаламжийн хүүгийн орлого	273,653,698.61	279,403,397.27
120004206	Гадаад зээзлийн хөрөнгөөр санхүүжсэн дамжуулан зээлийн хүүгийн орлого	830,410.48	69,802.27
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	4,859,771,322.96	-
120009	Бусад нийтлэг татварын бус орлого	8,084,830.00	-
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	40,740,000.00	13,588,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	255,483,400.00	211,200,600.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	255,483,400.00	211,200,600.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	255,483,400.00	211,200,600.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,020,132,276.11	2,264,304,810.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,617,536,453.01	1,199,842,669.64
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,368,384,171.58	1,046,066,685.14
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	476,694,586.17	404,547,185.02
210101	Үндсэн цалин	476,694,586.17	404,547,185.02
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,366,490.89	50,156,211.22
210201	Тэтгэврийн даатгал	59,366,490.89	50,156,211.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	111,361,312.33	96,061,669.40
210301	Гэрэл, цахилгаан	473,312.33	605,169.40
210302	Байрны түрээс	110,888,000.00	95,456,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	28,024,979.03	18,256,426.04
210401	Бичиг хэрэг	1,996,800.00	1,573,049.95
210402	Тээвэр, шатахуун	3,973,300.00	3,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,852,005.11	5,814,260.00
210404	Ном, хэвлэл	3,564,000.00	-
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	12,638,873.92	7,269,116.09
2107	Томилолт, зочны зардал	10,307,880.00	11,355,000.00
210702	Дотоод албан томилолт	10,307,880.00	11,355,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	597,348,947.44	412,274,780.79
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	597,348,947.44	412,261,780.37
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,000.00	13,000.42
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	85,279,975.72	53,415,412.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,804,234.81
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	85,279,975.72	51,611,177.86
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	249,152,281.43	153,775,984.50

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,351,299.18	530,454.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,351,299.18	530,454.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	243,800,982.25	153,245,530.50
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	243,800,982.25	153,245,530.50
22	Хөрөнгийн зардал	3,402,59,823.10	1,064,462,140.91
220	Хөрөнгө оруулалт	2,427,583,643.10	836,222,223.70
220001	Барилга байгууламж	2,427,583,643.10	836,222,223.70
221	Их засвар	408,073,300.90	216,759,916.30
221001	Их засвар	408,073,300.90	216,759,916.30
222	Тоног төхөөрөмж	566,938,879.10	11,480,000.91
222001	Тоног төхөөрөмж	566,938,879.10	11,480,000.91
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	732,701,038.89	(1,653,850,169.20)
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	788,451,212.54	4,176,123.17
14	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	788,451,212.54	4,176,123.17
145	Бусад орлого /олз/	788,451,212.54	4,176,123.17
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	788,451,212.54	4,176,123.17
145002	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз	335,369.64	-
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	98,650,503.24	122,114,666.51
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	98,650,503.24	122,114,666.51
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУСАД ҮР ДҮН (VI)=IV-V	689,800,709.30	(117,938,543.34)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,422,501,748.19	(1,771,788,712.54)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	5,388,908,421.57	473,358,362.47
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,133,425,021.57	262,157,762.47
120	Нийтлэг татварын бус орлого	5,133,425,021.57	262,157,762.47
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,133,425,021.57	262,157,762.47
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	273,653,698.61	262,157,762.47
120004201	Дансны үлдэгдэлд бодогдсон хүүгийн орлого	-	18,042,036.43
120004205	Батлан даалтын хөрөнгийн хадгаламжийн хүүгийн орлого	273,653,698.61	244,115,726.04
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	4,859,771,322.96	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	255,483,400.00	211,200,000.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	255,483,400.00	211,200,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	255,483,400.00	211,200,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,379,930,250.80	3,600,535,449.35
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,379,930,250.80	3,600,535,449.35
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,280,146,739.60	3,596,091,951.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	473,428,476.87	407,872,137.64
210101	Үндсэн цалин	473,428,476.87	407,872,137.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	59,366,490.91	50,156,211.21
210201	Тэтгэврийн даатгал	40,519,039.82	34,386,510.77
210202	Тэтгэмжийн даатгал	4,766,945.85	4,045,471.85
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,813,556.69	3,236,377.48
210204	Ажилгүйдлийн даатгал	933,358.97	747,568.28
210205	Эрүүл мэндийн даатгал	9,333,589.58	7,740,282.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	102,360,283.93	88,352,154.00
210301	Гэрэл, цахилгаан	430,283.93	550,154.00
210304	Байрны түрээс	101,930,000.00	87,802,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	26,345,638.35	17,002,068.20
210401	Бичиг хэрэг	1,878,909.09	1,465,031.77
210402	Тээвэр, шатахуун	3,973,300.00	3,600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,395,692.75	5,317,434.54
210404	Ном, хэвлэл	3,240,000.00	-
210406	Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	11,857,736.51	6,619,601.89
2107	Томилолт, зочны зардал	10,307,880.00	11,355,000.00
210702	Дотоод албан томилолт	10,307,880.00	11,355,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	607,524,829.22	3,019,550,145.86
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	607,514,829.22	3,019,537,145.44
210808	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,000.00	13,000.42
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	813,140.32	1,804,234.81
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	813,140.32	1,804,234.81
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	99,783,511.20	4,443,497.63
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,351,299.18	530,454.00

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	5,351,299.18	530,454.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	94,432,212.02	3,913,043.63
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	94,432,212.02	3,913,043.63
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	4,008,978,170.78	(3,127,177,086.89)
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	479,100.00	-
14	Үйл ажиллагааны бус орлого	479,100.00	-
140001	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	479,100.00	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	3,094,515,490.00	988,236,622.00
22	Хөрөнгийн зардал	3,094,515,490.00	988,236,622.00
220	Хөрөнгө оруулалт	2,207,435,728.00	780,291,183.00
220001	Барилга байгууламж	2,207,435,728.00	780,291,183.00
221	Их засвар	371,680,781.00	197,274,529.00
221001	Их засвар	371,680,781.00	197,274,529.00
222	Тоног төхөөрөмж	515,398,981.00	10,670,910.00
222001	Тоног төхөөрөмж	515,398,981.00	10,670,910.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(3,094,036,390.00)	(988,236,622.00)
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	788,115,852.90	4,176,123.17
145	Бусад орлого	788,115,852.90	4,176,123.17
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	788,115,852.90	4,176,123.17
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	-
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	788,115,852.90	4,176,123.17
		1,703,057,632.67	(4,111,237,585.72)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	10,327,800,612.24	12,030,858,235.91
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	12,030,858,235.91	7,919,620,650.19

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	/төгрөгөөр/ Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	8,013,611,975.50	8,013,611,975.50
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	8,013,611,975.50	8,013,611,975.50
Тайлант үеийн үр дүн	1,422,501,748.19	1,422,501,748.19
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	9,436,113,723.69	9,436,113,723.69
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,366,873.00	1,366,873.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	9,437,480,596.69	9,437,480,596.69
Тайлант үеийн үр дүн	(1,771,788,712.54)	(1,771,788,712.54)
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,665,691,884.15	7,665,691,884.15

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/					
Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
11000	Мөнгөн хөрөнгийн оны эхний үлдэгдэл	-	1,487,088,493.04	-	0.0
11100	Үүнээс: Банкин дахь харилцах дансны үлдэгдэл	-	1,487,088,493.04	-	0.0
11200	Кассын оны эхний үлдэгдэл	-	-	-	0.0
12	Татварын бус орлого	-	211,200,600.00	(211,200,600.00)	0.0
122005	Төсвөөс санхүүжих	-	211,200,600.00	(211,200,600.00)	0.0
14	ОРЛОГО	-	-	-	0.0
140020	Дансны орлого	-	-	-	0.0
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,607,565,600.00	4,583,041,792.49	23,237,026.28	99.4
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,619,240,600.00	3,594,274,716.49	23,148,648.28	99.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,619,240,600.00	3,594,274,716.49	23,148,648.28	99.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	407,872,300.00	407,872,137.64	162.36	100.0
210101	Үндсэн цалин	407,82,300.00	407,872,137.64	162.36	100.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	50,984,500.00	50,156,211.21	828,288.79	98.8
210201	Тэтгэврийн даатгал	34,669,600.00	34,386,510.77	283,089.23	99.4
210202	Тэтгэмжийн даатгал	4,078,800.00	4,045,471.85	33,328.15	99.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,263,000.00	3,236,377.48	26,622.52	99.4
210204	Ажилгүйдлийн даатгал	815,700.00	747,568.28	68,131.72	90.5
210205	Эрүүл мэндийн даатгал	8,157,400.00	7,740,282.83	417,117.17	96.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	88,372,000.00	88,352,154.00	19,846.00	100.0
210301	Гэрэл, цахилгаан	570,000.00	550,154.00	19,846.00	99.3
210304	Байрны түрээс	87,802,000.00	87,802,000.00	-	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	23,848,700.00	17,00,068.20	6,846,631.80	84.9
210401	Бичиг хэрэг	1,500,000.00	1,465,031.77	34,968.23	97.6
210402	Тээвэр, шатахуун	3,600,000.00	3,600,000.00	-	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,537,200.00	5,317,434.54	219,765.46	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,211,500.00	6,619,601.89	6,591,898.11	50.1
2107	Томилолт, зочны зардал	14,955,000.00	11,355,000.00	3,600,000.00	75.9
210702	Дотоод албан томилолт	14,955,000.00	11,355,000.00	3,600,000.00	75.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	3,033,208,100.00	3,019,537,145.44	11,853,719.33	99.6
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,033,208,100.00	3,019,537,145.44	13,670,954.56	99.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		1,804,234.81	(1,804,234.81)	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	988,325,000.00	988,236,622.00	88,378.00	99.4
220001	Барилга байгууламж	780,300,000.00	780,291,183.00	8,817.00	100.0
221001	Их засвар	197,300,000.00	197,274,529.00	25,471.00	99.9
222001	Төног төхөөрөмж	10,725,000.00	10,670,910.00	54,090.00	100.0

Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төслийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ				
26	26	-	530,454.00	(530,454.00)	
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	530,454.00	(530,454.00)	
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	244,115,726.04	(244,115,726.04)	
35	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	244,115,726.04	(244,115,726.04)	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	244,115,726.04	(244,115,726.04)	
12000	Нийтлэг татварын бус орлого	-			
12000	Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	7,919,620,650.18		
12100	Үүнээс: Төрийн сангийн харилцах дансны үлдэгдэл	-	1,721,084,923.75	-	
12200	Тусламжийн орлого	-			
	АЖИЛЛАГСДЫН ТОО	18	18		100.0
	Удирдах ажилтан	2	2		100.0
	Гүйцэтгэх ажилтан	14	14		100.0
	Үйлчлэх ажилтан	1	1		100.0
	Гэрээт ажилтан	1	1		100.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Санхүүгийн тайлангийн хувьд материаллаг буруу илэрхийлсэн алдаа, зөрчил байхгүй тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/			
			Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 571,438.1 мянган төгрөгийн, зарлагын 698,362.5 мянган төгрөгийн, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэрийн 971,243.8 мянган төгрөгийн 22 гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн	1	2,241,044.3	1	2,241,044.3		
Дүн	1	2,241,044.3	1	2,241,044.3		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил						
Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төрийн Аудитын байгууллагад аудит хийлгүүлэхээр хүргүүлсэн санхүүгийн тайланд санхүүгийн үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг бэлтгэхдээ эхний үлдэгдлийг тайлагнаагүй.	1				1	
Дүн	1				1	
Нийт дүн	2	2,241,044.3	1	2,241,044.3	1	